

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН “ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ”-Г 2024 ОНД САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар/

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилт	Хэрэгжилт ийн хувь
Нэг. Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр					
1.1	Гаалийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар дахь /цахим/ үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод, нээлттэй эсэхэд дүн шинжилгээ хийх, дутуу мэдээллүүдийг нэмж байршуулах, тогтмол шинэчлэх;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллүүдийг ил тод байршуулсан байх.	2-4 дүгээр улирал	<p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагаас эхний хагас жилд “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийг хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас shilen.gov.mn сайтын 2.0 хувилбарт мэдээллээ илгээж, тайлагнах чиглэлээр 2 удаа цахим сургалт зохион байгуулсан. Тус сургалтад 3 албан хаагч хамрагдсан. 2024 оны 2 дугаар улиралд customs.gov.mn сайтын мэдээ, мэдээллийг шинэчлэх чиглэлээр Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудад мэдээллээ шинэчилж байх тухай чиглэлийг 11 хүргүүлж, тус сайтын цэс бүрийн мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай байлгах ажлын хүрээнд үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдал болон авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр нийт 36 мэдээллийг байршуулсан. “Төсвийн гүйцэтгэл”-ийг сар бүр буюу 6 удаа, “Худалдан авах ажиллагаа”-ны тендерийн урилгыг 8 удаа зарласныг хугацаанд байршуулан ажилласан. Мөн 2023 оны тендерийн урилга, түүний үр дүн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний тайлан, жилийн эцсийн тайланг 2024 оны 1 дүгээр улиралд байршуулсан. Гаалийн байгууллагын веб сайтад Нийтийн мэдээллийн ил байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгах аргаар заасан мэдээллийг гаалийн байгууллагын www.customs.gov.mn веб сайтын үндсэн болон дэд цэсэд тогтмол шинэчлэн байршуулж, байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллүүдийн шилэн индексийн тайланг 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Цахим хөгжлийн яамны Shilen.gov.mn сайтад үнэлүүлэхээр илгээн ажилласан.</p> <p>/1.1 дэх арга хэмжээний нотломжуудыг хавсаргав./</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллээс гаалийн байгууллагад хамааралтай тогтмол болон хугацаатай 30 мэдээлэл байршуулахаар тусгагдсан. Дээрх хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд 2024 онд давхардсан тоогоор 50 мэдээллийг хугацаанд нь цахим хуудаст байршуулан ажилласан. Хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй болно. 2023 онд www.customs.gov.mn веб</p>	100

				сайтыг Цахим хөгжлийн яамнаас 100 хувь гэж үнэлсэн бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар шилэн индексийн тайланг 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Цахим хөгжлийн яамны Shilen.gov.mn сайтад үнэлгээ хийлгэхээр хүргүүлээд байна.	
				Үнэлгээ: 100 хувь	
1.2	Харьяа гаалийн газар, хороодоос гаалийн бүрдүүлэлт, хяналт, шалгалтыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн /үүрэг, чиглэл/ ажил, арга хэмжээг тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин, иргэд олон нийтэд сурталчлан, таниулах ажлыг зохион байгуулах;	- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин, иргэд олон нийтэд сурталчлан, таниулсан байх; - Үр дүнд үндэслэн тогтмол дүн шинжилгээ хийсэн байх.	2-4 дүгээр улиралд	ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагаас эхний хагас жилийн байдлаар харьяа гаалийн газар, хороодтой хамтран гаалийн бүрдүүлэлт, хяналт, шалгалтыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний агуулга бүхий 20 мэдээ, мэдээлэл бэлтгэн пэйж хуудас, твиттер, веб сайтаар түгээн ажилласан. <ul style="list-style-type: none"> ➢ Гаалийн ерөнхий газрын харьяа Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын албан хаагчдад “Шуудангийн гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд анхаарах зарим асуудлууд” сургалт, уулзалт, ➢ “Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын албан хаагчдад “Гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд анхаарах зарим асуудлууд” сургалт, уулзалт, ➢ Улаанбаатар хот дахь гаалийн газрын албан хаагчдад “Үйл ажиллагаанд анхаарах зарим асуудлууд” сургалт, уулзалт, ➢ Дархан-Уул аймаг дахь гаалийн газрын албан хаагчдад “Үйл ажиллагаанд анхаарах зарим асуудлууд” сургалт, уулзалт, ➢ Сэлэнгэ аймаг дахь гаалийн газруудын албан хаагчдад “Үйл ажиллагаанд анхаарах зарим асуудлууд” сургалт, уулзалтуудыг танхимаар зохион байгуулан ажилласан. Дээрх сургалт, уулзалтын талаар тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин, иргэд олон нийтэд сурталчлан, таниулах ажлыг зохион байгуулан 18 видео яриа, 2 зурган мэдээг нийтлэн олон нийтэд түгээн ажилласан. /1.2 дахь арга хэмжээний нотломжуудыг хавсаргав./ ХҮРСЭН ТҮВШИН: Эхний хагас жилийн байдлаар гаалийн байгууллагын хэмжээнд 20 мэдээ, мэдээлэл бэлтгэн пэйж хуудас, твиттер, веб сайтаар түгээн ажилласан. Харьяа гаалийн 5 газар, хороодод танхимын сургалт зохион байгуулан үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж, чиглэл үүрэг даалгавар өгч ажилласан.	70
1.3	Харьяа гаалийн газар, хороодод ажиллаж байгаа албан хаагчдаас “Сэтгэл ханамжийн судалгаа”-г авах;	- Судалгааны үр дүнд үндэслэн учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг бодит байдалд арилгасан байх,	2-4 дүгээр улиралд	ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар харьяа гаалийн газар, хороодод ажиллаж байгаа албан хаагчдаас “Сэтгэл ханамжийн судалгаа”-г авах ажлын хүрээнд дараах харьяа 3 гаалийн газар, хороодын албан хаагчдаас “Сэтгэл ханамжийн судалгаа”-г авч ажилласан. “Сэтгэл ханамжийн судалгаа”-г авч ажиллаагүй харьяа гаалийн газар, хороод сүүлийн хагас жилд багтаан авч ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. Албан тушаалын тодорхойлолт боловсруулах мэдээлэл цуглуулах зорилгоор 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр 13 асуумж бүхий судалгааг цахимаар авсан. https://forms.gle/mYu7s1ZQnfK4ZN547 , Гаалийн байгууллагын хэмжээнд спортын зэрэг, цолтой албан хаагчдын судалгааг нэгтгэн гаргах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр 5 асуумж бүхий судалгааг цахимаар авсан.	100

		<p>- Урьдч илан сэргийлэх арга хэмжээ авсан талаарх мэдээллийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд сурталчлан, таниулсан байх.</p>	<p>https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSfRIMw8QW1EjcWabRWC6_hRUB8z10CMdKHynWzSNZ9C7PhMA/viewform?fbclid=IwZXh0bgNhZW0CMTAAAR2bVdASba5ffTASFbHyWeY0H7ITclx99gAXWIYLUG31QUGRPACD344IZB8_aem_ZmFrZWR1bW15MTZieXRlcw, Байгууллагын соёлын талаарх 10 асуулттай судалгааг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр нийт албан хаагчдаас цахимаар авсан. https://l.facebook.com/l.php?u=https%3A%2F%2Fdocs.google.com%2Fforms%2Fd%2Fe%2F1FAIpQLSdD-jKNJxKY05fX3wngCBQVgdd5nvYZiLCWGNRH, Гаалийн байгууллагын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг нийт албан хаагчдаас цахимаар авсан. https://forms.gle/dbhgSPDUhULsFHw36 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл /телевиз, сайт г.м/-д тухай бүр цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой ярилцлага өгч, сурвалжилга бэлтгэх нөхцөл боломжоор хангаж ажилласан.</p> <p>1. <u>Замын-Үүд дэх гаалийн газар:</u> Жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэх, байгууллагын жендерийн стратегийг хэрэгжүүлэх чадавх, жендерийн тэгш байдлын ахиц, дэвшлийг илрүүлэх зорилготой “Жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаандаа нэгтгэх чадавх бүрдүүлэлт” сэдэвт байгууллагын түвшний өөрийн үнэлгээний 20 асуумж бүхий цахим судалгааг 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр авсан. https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSfOtRPSJlu0NkeUrNuzGYfUctZvExbfilHA_ov67YEAO1shmMA/viewform,</p> <p>2. <u>Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар:</u> Удирдах албан тушаалтнууд болон гаалийн улсын ахлах байцаагч нарын ёс зүй, харилцаа хандлага, ур чадварыг тодорхойлох санал асуулга авч 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Удирдлагын өргөтгөсөн хуралдаан зохион байгуулж, хамт олноос өгсөн үнэлгээг гаалийн улсын ахлах байцаагч, удирдах албан тушаалтнуудад танилцуулан, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, үүрэг чиглэл өгсөн. Санал асуулгын үнэлгээнээс харахад нийт гаалийн улсын ахлах байцаагч нарын ёс зүй, мэдлэг чадварын үнэлгээ сайн, хандлага, харилцаа болон багаар ажиллах чадвараа сайжруулах шаардлагатай харагдаж байна. Санал асуулгын үнэлгээнээс харахад нийт удирдах албан тушаалтнууд ёс зүй, багаар ажиллах чадвараа сайжруулах шаардлагатай харагдаж байна. Байгууллагын соёл, ёс зүйн уур амьсгалын өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор 9 асуулгаар байгууллагын албан хаагчдаас санал, асуулга авсан. Санал асуулгын дүгнэлтээр байгууллагын нийт албан хаагчдын харилцаа, хандлагыг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан. Дээрх 2 санал асуулгын хүрээнд тогтвортой байдал буюу байгууллагын соёл, ёс зүйн уур амьсгалыг байнга сайжруулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулан ажиллаж, уг ажлын хүрээнд албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлж, төрийн үйлчилгээг аж ахуйн нэгж, иргэдэд хөнгөн шуурхай хүргэх зорилгоор “Чадварлаг, ёс зүйтэй гаальчин” сэдэвт аян зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>3. <u>Увс аймаг дахь гаалийн газар</u> 2024 оны 4 дүгээр сард байгууллагын нийт албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшин, ажлын орчин, хамт олны харилцаа, байгууллагын соёлыг тодорхойлж, албан хаагчийн бүтээмжид нөлөөлөх хүчин зүйлсийг судлах зорилгоор байгууллагын дотоод facebook</p>	
--	--	--	---	--

				<p>messenger болон viber группт судалгааны линк байршуулан 2024 оны 5 дугаар сарын 20-25-ны хооронд онлайн хэлбэрээр буюу линкээр нийт 35 асуулгаар авч, дүнг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийж ажилласан. Судалгаанд газрын ТТ-28, ТҮ-26 нийт 54 албан хаагчаас 37 албан хаагч буюу 68.5% хамрагдсан болно. Судалгааны үр дүнд албан хаагчдын санал, хүсэлтийн дагуу газрын удирдах албан тушаалтнууд тодорхой арга хэмжээ авч, удирдах удирдуулах ёс зүйг баримтлан 7 хоног бүр хамт олны хурал зохион байгуулж, хурлын шийдвэрээр гарсан ажлын хэрэгжилт зохион байгуулалтын асуудлыг дараагийн хурлаар хэлэлцүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, жендерийн асуудлаар мэргэшсэн мэргэжилтний урьж, сургалт мэдээлэл хийлгэх, гаалийн улсын байцаагчийн ёс зүй-үйлчилгээний стандартын талаар дүрэм журмыг таниулах, сургалт зохион байгуулах, уг дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, гаалийн хяналт бүрдүүлэлт болон дотоод хяналт зохион байгуулалттай холбоотой цаг үеийн шинжтэй асуудлыг тухай бүр шийдвэрлэж хамт олонд ил тод нээлттэй мэдээлэх, ажлын гүйцэтгэл, үр дүнг бодитой үнэлж, удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. /1.3 дахь арга хэмжээний нотломжуудыг хавсаргав./</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар харьяа гаалийн газар, хороодод ажиллаж байгаа албан хаагчдаас “Сэтгэл ханамжийн судалгаа”-г авах ажлын хүрээнд харьяа 3 гаалийн газар, хороодын албан хаагчдаас “Сэтгэл ханамжийн судалгаа”-г авч үр дүнг нэгтгэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл /телевиз, сайт г.м/-д ярилцлага өгч ажилласан.</p> <p style="text-align: center;">Үнэлгээ: 100 хувь</p>	
1.4	<p>Харьяа гаалийн газар, хороодын албан хаагч нарт дараах хууль тогтоомжийг чанд мөрдүүлэн, хэрэгжилтийг хангуулж, баталгаа гаргуулан, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан байна. Үүнд: -Авлигын эсрэг хууль,</p>	<ul style="list-style-type: none"> - Албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх; - Албан хаагчаар баталгаа гаргуулсан байх; - АХА болон бусад уралдаан, тэмцээн зохион байгуулах. 	2-4 дүгээр улиралд	<p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар албан хаагчдад соён гэгээрүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Сургалтын төвд:</u> Гаалийн байгууллагад албан хаагч болон бүртгэгдсэн мэргэжилтэн нарт “Авлигын гэмт хэрэг, шалтгаан, хор хөнөөл” сэдвээр 4 удаагийн 8 цаг, “Гаалийн улсын байцаагчийн ёс зүй, сахилга, хариуцлага, үйлчилгээний стандарт ба авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 7 удаагийн 18 цаг буюу нийт 11 удаагийн 26 цагийн сургалтыг давхардсан тоогоор 415 албан хаагчдыг хамруулсан. 2. <u>Улаанбаатар хот дахь гаалийн газарт:</u> “Авлигын эсрэг” сургалтын хөтөлбөрийн дагуу “Авлигын гэмт хэрэг, шалтгаан, хор хөнөөл”, “Авлигын гэмт хэрэг болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, түүний хууль зүйн үндэслэлийг шалгах шалгалт, илэрсэн зөрчил, цаашид анхаарах асуудал” сэдэвт сургалтуудад 136 албан хаагчдыг хамруулсан. 3. <u>Замын-Үүд дэх гаалийн газарт:</u> “Гаалийн улсын байцаагчийн ёс зүй” сэдэвт сарын аяныг 1 сарын хугацаанд зохион байгуулсан. Аяны хүрээнд хууль, дүрэм, журам, стандартыг гаалийн улсын байцаагч нарт танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан. “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт сургалт, “Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт”, “Авлига албан тушаалын гэмт хэргээс ангид байх” сэдэвт сургалт, гэмт хэрэг зөрчлөөс ангид байх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалт, 	100

<p>-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, -ЗГ-ын 2009 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм", -ГЕГ-ын даргын 2009 оны 534 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм", -ГЕГ-ын даргын 2016 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт", ГЕГ-ын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын</p>			<p>Төрийн албан хаагчийн харилцаа, хандлагын өөрчлөлт, бүтээмжийг дэмжих сэдэвт сургалт, Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх сэдэвт сургалтуудыг танхимаар болон цахимаар зохион байгуулан ажилласан. Сургалтад давхардсан тоогоор 782 албан хаагч хамрагдсан.</p> <p>4. <u>Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газарт:</u> "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалт, "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй сахилга хариуцлага" сэдэвт сургалт, "Гаалийн харилцаанд оролцогчид тавих гаалийн хяналт" сэдэвт сургалт, "Авлига, хүнд суртал, гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ" сэдэвт сургалт, "Улсын хилээр нэвтрүүлэх оюуны өмчид тавих гаалийн хяналт" сэдэвт танхимын сургалтуудыг давхардсан тоогоор 190 албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>5. <u>Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт:</u> ХАСХОМ мэдүүлэх болон ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар" сэдэвт сургалт, "Төрийн албан хаагч нарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчдын ёс зүй, сахилга, хариуцлага, авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалт, "Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага" сэдэвт сургалт, "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ын хэрэгжилт сэдэвт сургалт, "Авлига, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалт, Төрийн албан хаагчийн ёс зүй, Байгууллагын соёл сэдэвт танхимын сургалтуудыг давхардсан тоогоор 462 албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>6. <u>Гашуунсухайт дахь гаалийн газарт:</u> Албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй, эсхүл бусдад дамжуулахгүй байх чиглэлээр, мөн холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдүүлэн, хэрэгжилтийг хангуулах талаарх танхимын сургалтыг зохион байгуулсан.</p> <p>7. <u>Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт:</u> "Авлигын эсрэг хууль тогтоомж, түүний хэрэгжилт" сэдэвт сургалт, "Гаалийн албан хаагчийн авлигын гэмт хэрэгт холбогдох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт, "Гаалийн улсын байцаагчийн ёс зүй" сэдэвт танхимын сургалтуудыг давхардсан тоогоор 46 албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>8. <u>Орхон аймаг дахь гаалийн газарт:</u> "Авлигын эсрэг хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хэрэгжилт сэдэвт сургалт, "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ийн хэрэгжилт сэдэвт сургалт, "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Гаалийн улсын байцаагчийн ёс зүй", "Гаалийн улсын байцаагчийн сахилгын тусгай дүрэм"-ийн хэрэгжилт сэдэвт сургалт, "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ийн хэрэгжилт сэдэвт сургалт, Авлигатай тэмцэх газраас "Гаалийн ерөнхий газрын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө", "Шударга байдлын үнэлгээг сайжруулах төлөвлөгөө"-ний хэрэгжилт сэдэвт сургалтуудыг давхардсан тоогоор 135 албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>9. <u>Баян-Өлгий аймаг дахь гаалийн газарт:</u></p>	
---	--	--	--	--

	хөдөлмөрийн дотоод журам”.			<p>“Манлайлах ур чадвар”, “Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм, харилцаа, хандлага”, “Байгууллага, хувь хүний нууцын тухай”-ийн хэрэгжилт, “Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний үйлчилгээний стандарт”, “Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам”-ын хэрэгжилт, “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилт сэдвээр танхимын сургалтуудыг давхардсан тоогоор 19 албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>10. <u>Увс аймаг дахь гаалийн газарт:</u> “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Гаалийн улсын байцаагчийн ёс зүй”, “Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Гаалийн улсын байцаагчийн ёс зүй”, “Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Байгууллагын соёл”, “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилт сэдвээр танхимын сургалтуудыг давхардсан тоогоор 73 албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>11. <u>Сайншанд дахь гаалийн газарт:</u> “АХА” тэмцээнийг зохион байгуулсан.</p> <p>12. <u>Дархан-Уул аймаг дахь гаалийн газарт:</u> Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, “Төрийн албан хаагчийн ёс зүй, үүрэг, хариуцлага”, Авлигын эсрэг хууль, НАНБХАСЗАСЗУС тухай хууль, Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтээр танхимын сургалтуудыг давхардсан тоогоор 37 албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>13. <u>Говь-Алтай аймгийн Бургастай дахь гаалийн хороонд:</u> Удирдах, гүйцэтгэх албан тушаалтнуудад албан үүрэг, эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглахгүй байх, өөртөө болон хэн нэгэнд давуу байдал олгохгүй, хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоос ангид тэгш шударгаар хэрэгжүүлж, аливаа ашиг сонирхлын зөрчилд өртөхгүй, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Гаалийн тухай хууль Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль эрүүгийн хуулийн хэрэгжилт сэдэвт танхимын сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>14. <u>Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хороонд:</u> Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, Олон улсын худалдааг хөнгөвчлөх сэдэвт танхимын сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>15. <u>Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороонд:</u> Гаалийн улсын байцаагч нарыг ёс зүй, авлигын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр танхимаар сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>16. <u>Ханги дахь гаалийн газарт:</u> Зөрчил шалган шийдвэрлэх, Төрийн албаны тухай хууль болон гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, хөдөлмөрийн дотоод журмыг чанд сахин ажиллах, гаалийн улсын байцаагчийн ёс зүй, зөрчил шалган шийдвэрлэх тухай,</p>
--	----------------------------	--	--	--

				<p>авлигын эсрэг хууль, авлигаас урьдчилан сэргийлэх сэдэвт танхимаар сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар албан хаагчаар бүрээр Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, ЗГ-ын 2009 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм", Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 534 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм", 2016 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт", 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ыг чанд мөрдүүлэн, хэрэгжилтийг хангуулахаар 1046 албан хаагчаар баталгаа гаргуулан авч нэгтгэсэн. /баталгаа гаргавал зохих 1226 албан хаагчаас баталгаа гаргасан 1046, баталгаа гаргаагүй 180 үүнээс өвчтэй 16, чөлөөтэй 34, ээлжийн амралттай 85, бусад 45/. /1.4 дэх арга хэмжээний нотломжуудыг хавсаргав./</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар харьяа 15 гаалийн газар, хороодын давхардсан тоогоор 2763 албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулан ажиллаж сургалтаар олж авсан мэдлэгийг бататгах үүднээс АХА тэмцээнийг амжилттай зохион байгуулан ажилласан. Гаалийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажиллуулах талаарх баталгааг нийт албан хаагчдын 85.3 хувиар гаргуулан авч ажилласан.</p> <p style="text-align: center;">Үнэлгээ: 100 хувь</p>	
1.5	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд давхар хяналт хийх;	<ul style="list-style-type: none"> - Давхар хяналтыг сар бүр зохион байгуулсан байх; - Давхар хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор нэгжийн удирдлага д үүрэг чиглэл тухай бүр өгч үр дүнг тооцсон байх. 	2-4 дүгээр улиралд	<p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар харьяа гаалийн газар, хороодод хийгдэж буй гаалийн бүрдүүлэлтэд эрсдэл тооцож, татвараас зайлсхийх зөрчилд хийсэн судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан гаалийн зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлэх, улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлын хүрээнд "гааль зөвшөөрөв" төлөвт 11 удаагийн дахин шалгалтыг зохион байгуулж, үр дүнг ирүүлэх ажлын чиглэлийг харьяа гаалийн газар, хороодын дарга нарт тухай бүр албан бичгээр чиглэл хүргүүлэн ажилласан.</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Эхний хагас жилийн байдлаар дахин шалгалтаар гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн 10 зөрчил илрүүлж, 83.3 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 41.7 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчлийн тоо 2.5 дахин, нөхөн төлүүлсэн татварын дүн 2.6 дахин, торгуулийн дүн 63.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Дахин шалгалтын үр дүнд гаалийн хяналт шалгалт хийхдээ ажлын хариуцлага алдсан 5 гаалийн улсын ахлах байцаагч, 5 гаалийн улсын байцаагч нарт шалгалтын ажиллагаа хийгдэж, Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал оруулсан.</p> <p>/1.5 дах арга хэмжээний нотломжуудыг хавсаргав./</p> <p style="text-align: center;">Үнэлгээ: 100 хувь</p>	100

1.6	Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулж байгаа цаг хугацааг бууруулах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах;	<ul style="list-style-type: none"> - Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийсэн байх; - Үр дүнгээс хамааран гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа 5 хувиар буурсан байх. 	2-4 дүгээр улиралд	<p>ХЭРЭГЖИЛТ: “Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгаа”-г хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж судалгааны дүнг нэгтгэн гаргаж ажилласан. Судалгаанд Бүрдүүлэлтийн цаг хугацааны өмнөх таван удаагийн судалгааны дүн, 2019, 2022, 2023 оны судалгаанд хамрагдсан 17,352 гаалийн мэдүүлэг, 100,152 барааны бичлэгт хамаарах, таван дэд программаас авсан давхардсан тоогоор 18 төрлийн 266,309 мянган өгөгдөл /мэдээллийг хамруулсан. Сонгож авсан хугацаанд гаалийн газар, гаалийн хяналтын бүсэд хийгдсэн бүрдүүлэлтийн мэдээллийг КАИС-ийн таван дэд программаас татаж, харьцуулан, хилийн гаалийн байгууллага дээр, хилээс гүний гаалийн байгууллагын хяналтад илгээж, барааг эзэнд нь олгох хүртэлх цаг хугацааг тооцоолон, өмнөх судалгаатай харьцуулж, цаг хугацааны өөрчлөлтийг гаргасан. ГЕГ-ын 2019 оны Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаатай 2023 оны судалгааг сонгон авсан гаалийн газар, хороодоор харьцуулахад “Тээвэрлэлт, Татвар төлөх хугацаа, Хорио цээрийн шалгалт, Гаалийн лабораторийн шинжилгээ”-нд зарцуулсан хугацаа нь бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлжээ. Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгааг 2019 оны судалгаатай харьцуулахад зөрүүтэй байгаа нь өгөгдөл/ мэдээлэл цуглуулсан, боловсруулсан аргачлалын хувьд ялгаатай байгаатай холбоотой. Үүнтэй уялдуулан хоёр судалгааны ижил болон ялгаатай талыг харьцуулан харуулсан. “Татвар төлөх хугацаа” нь бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн ба 2022 онд дунджаар 20 цаг, 19 минут, 2023 онд дунджаар 19 цаг 38 минут тус тус зарцуулсан. Мэдүүлэгч нар бараагаа хүлээж авахгүй цаг хугацаа алдаж байгаа нь улаан төлөвтэй мэдүүлэгт хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч, улбар шар, ногоон төлөвтэй мэдүүлэгт хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч дээр хуваарилагдсан цаг хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. Мөн хяналтын улбар шар болон ногоон төлөвтэй бараг ойролцоо гарсан нь “Татвар төлөх хугацаа” өндөр байгаатай холбоотой бөгөөд нэг болон олон нэр төрөлтэй бараа эсэхээс үл хамаарч бичиг баримт болон бараанд хийх шалгалтад ижил хугацаа, эсхүл нэг нэр төрлийн бараанд илүү хугацаа зарцуулсан байсан. Шинжилгээг голч утга (медиан)-аар авч үзэхэд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацаа 2023 онд 267.5 минут байгаа нь 2022 оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар өссөн бөгөөд үүнд хорио цээрийн шалгалтад 2023 онд зарцуулсан дундаж хугацаа болох 841 минут/14 цагийг 2022 оны мөн үетэй харьцуулахад 136 минут/16 хувиар өссөн нь нөлөөлжээ. Шинжилгээний үр дүнд “Хорио цээрийн шалгалт болон ГУАБ зөвшөөрөх” үе шат нь дундаж хугацаанаас хэт хазайлттай гарсан. Энэ нь тухайн үе шатанд тооцоолол хийхэд хүндрэл учруулах эрсдэлийг бий болгожээ. Бусад үе шатын хувьд 40-124 минут/0.7-2.06 цагаар буурсан байна.</p> <p>/1.6 дах арга хэмжээний нотломжуудыг хавсаргав./</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Бүрдүүлэлтийн үе шат бүрээс бичиг баримтын шалгалтад зарцуулсан дундаж хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 124 минут буюу 2.77 дахин буурсан нь бичиг баримтын шалгалтыг нэг цэгт төвлөрүүлсэнтэй холбоотой. Энэхүү судалгааны шинжилгээг дундаж утгын хүрээнд авч гүйцэтгэхэд 2023 онд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 8 хувиар бууруулсан дүн гарсан.</p> <p style="text-align: center;">Үнэлгээ: 100 хувь</p>	100
Хоёр. Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр					

2.1	Харьяа гаалийн газар, хороодын албан хаагч нар албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй, эсхүл бусдад дамжуулахгүй байх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах;	<ul style="list-style-type: none"> - Албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх; - Албан хаагчдаар баталгаа гаргуулсан байх. 	2-4 дүгээр улиралд	<p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар харьяа гаалийн газар, хороодоос Улаанбаатар хот дахь гаалийн газар, Замын-Үүд дэх гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газар, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар Говь-Алтай аймгийн Бургастай дахь гаалийн хороо, Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хороо, Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороо, Ханги дахь гаалийн газруудын албан хаагчдад албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй, эсхүл бусдад дамжуулахгүй байх чиглэлээрх сургалтыг танхимаа зохион байгуулан ажилласан. Мөн албан хаагчдаас албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй, эсхүл бусдад дамжуулахгүй байх чиглэлээр баталгаа гаргуулан авч байгууллагын хэмжээнд баталгаа гаргавал зохих 1226 албан хаагчаас 1046 албан хаагчаар баталгаа гаргуулан ажилласан. Баталгаа гаргаагүй 180 албан хаагчаас өвчтэй 16, чөлөөтэй 34, ээлжийн амралттай 85, бусад 45/ /2.1 дэх арга хэмжээний нотломжуудыг хавсаргав./</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар харьяа 15 гаалийн газар, хороодын давхардсан тоогоор 2763 албан хаагчдад албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй, эсхүл бусдад дамжуулахгүй байх чиглэлээрх сургалтыг танхимаар сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулан ажиллаж сургалтад оролцсон албан хаагчдаас “Албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй, эсхүл бусдад дамжуулахгүй” гэсэн баталгааг бичгээр гаргуулан авч ажилласан.</p> <p style="text-align: center;">Үнэлгээ: 100 хувь</p>	100
2.2	Авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэн авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлсэн албан хаагчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй байх;	<ul style="list-style-type: none"> - Авлигын зөрчлийн талаар мэдээлэл өгөх боломжийг сурталчилсан байх; - Мэдээ, мэдээллийн мөрөөр хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, буруутай албан хаагчдад 	2-4 дүгээр улиралд	<p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагаас эхний хагас жилд мэдээллийн “Нэгүн”, “Арслан” сайтуудаар дамжуулан “Гаалийн албан хаагчидтай холбоотой гомдол, мэдээллийг Гаалийн лавлах 1800-1281 утсаар, бичгээр болон биечлэн ирж өгөх боломжтой болох” талаар мэдээлэл өгч ажилласан. Гаалийн байгууллагад эхний хагас жилийн байдлаар албан хаагчидтай холбоотой гомдол, мэдээлэл цаасан хэлбэрээр нийт 8 удаа, Засгийн газрын 11-11, Гаалийн лавлах 1800-1281 утсанд нийт 434 гомдол ирсэн үүнээс Гаалийн улсын байцаагчийн ёс зүйтэй холбоотой 30, Гаалийн зөрчилтэй холбоотой 7, Гаалийн цахим сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаатай холбоотой 3, Гаалийн үнэ үнэлгээ, бичиг баримттай холбоотой 134, Гаалийн хорио цээрийн хяналт, үйл ажиллагаатай холбоотой 10, Гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлттэй холбоотой 161 дуудлага, мэдээлэл ирсэн байна.</p> <p>Дээрх гомдол, мэдээллийг харьяалагдах нэгж, албан тушаалтанд шилжүүлэн шалгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Мөн Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэст 2024 оны эхний хагас жилийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, Гаалийн лавлах 1800-1281 утас, Засгийн газрын 11-11 төвөөс нийт 32 гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч, албаны дотоод хяналт, шалгалтыг явуулсан. Тус 32 гомдол, мэдээлэлд холбогдуулан 85 албан хаагчид албаны дотоод шалгалтыг явуулж, тайлбар, тодруулга авч ажилласан нь Сахилгын хороонд шилжүүлсэн 25, Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан 4, Сахилгын хорооноос нийт 5 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан. Сахилгын арга хэмжээ авагдсан 9 албан хаагч байгаа бөгөөд сахилгын шийтгэлийг төрлөөр нь авч үзвэл Албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар 20 хувиар бууруулах шийтгэл 4, Сануулах</p>	100

		хариуцлаг а тооцсон байх.		<p>1, Албан тушаалыг 3 сарын хугацаагаар бууруулах 1, Гаалийн улсын байцаагчийн эрхийг 6 сарын хугацаатай хасах 3 сахилгын шийтгэлийг тус тус ногдуулсан байна.</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагад эхний хагас жилийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ГЕГ-ын 1800-1281 гомдол мэдээлэл хүлээн авах тусгай дугаар, Засгийн газрын 1111 төвөөс ирүүлсэн нийт 32 гомдол мэдээлэлтэй холбогдуулан давхардсан тоогоор 85 албан хаагчдад албаны дотоод хяналт, шалгалт явуулж хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. Үүнээс 2 гомдол мэдээллийг харьяаллын дагуу Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажилласан. Гомдол мэдээллийн дагуу шалгагдсан албан хаагчийн тоо өмнөх оны мөн үеэс 34,6%-иар, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын тоо өмнөх оны мөн үеэс 30,7%-иар буурсан үзүүлэлттэй байгаа нь албан хаагчдын хууль сахилтын түвшин нэмэгдэж байгаагийн илрэл юм.</p> <p style="text-align: center;">Үнэлгээ: 100 хувь</p>	
2.3	Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүх албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулах арга хэмжээ авах, санал асуулгын үр дүнд үндэслэн Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг бодитой авч хэрэгжүүлэх;	- Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байх; - АТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байх.	2-4 дүгээр улиралд	<p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын хэмжээнд байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулах арга хэмжээг Замын-Үүд дэх гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газрын албан хаагчдаас санал асуулгыг авч ажилласан.</p> <p>1. <u>Замын-Үүд дэх гаалийн газарт:</u> “Олон улсын гаалийн өдөр”-ийг тохиолдуулан “Тангараг сануулах арга хэмжээний үеэр Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайваны 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02/316 албан бичгийг танилцуулж, “Дунд шатны удирдах албан тушаалтнуудын ажилдаа хандах хандлага, мэргэжил ёс зүй, ур чадвар”-ыг нийт 109 гаалийн улсын байцаагчаар үнэлүүлж, дүнг комисс томилон газар дээр нь нэгтгэж, танилцуулсан. Гаалийн улсын байцаагч нараас дунд шатны удирдах албан тушаалтнуудын манлайллыг нэмэгдүүлэх, гаалийн улсын байцаагч нарыг “Мерит” зарчмыг баримтлан албан тушаал дэвшихэд удирдлагын зүгээс анхаарч дэмжлэг үзүүлэх, гаалийн улсын ахлах байцаагч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулах гэх мэт саналуудыг ирүүлсэн. Дунд шатны удирдах албан тушаалтнуудыг үнэлсэн санал асуулгын үр дүн болон шинээр томилогдон ирж буй албан хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах шаардлага үүссэн тул “Замын-Үүд дэх гаалийн газрын танилцуулах сургалтын удирдамж”-ыг боловсруулан батлуулж, тус газарт томилогдсон 6 гаалийн улсын ахлах байцаагч, 13 гаалийн улсын байцаагч, 7 дадлагажигч нарт ажлын байрны танилцуулга, тус газрын онцлог анхаарах асуудлуудын талаар мэргэшүүлэх сургалт хийж, бие даан судлах хууль, тогтоомж, дүрэм, журам, тушаал шийдвэрүүдийг файлаар илгээж мэдээллээр хангасан. Мөн нууцын баталгаа гаргуулах, Ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн болон үүсэж болзошгүй тохиолдлыг тайлбарлах” ажлыг зохион байгуулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авах тухай 2024 оны 72/73 дугаартай мөрдөгчийн мэдэгдэл, 2024 оны 49 дугаартай мөрдөгчийн мэдэгдэл тус тус ирүүлсний дагуу албан хаагч нарт цаг тухай бүрд нь танилцуулж, шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр албаны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ажил, арга хэмжээ болгон тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2. <u>Баян-Өлгий аймаг дахь гаалийн газарт:</u></p>	70

				<p>Гаалийн улсын ахлах байцаагч нарт ёс зүй, харилцаа хандлагын талаарх нууц санал асуулга хийж тус газрын 30 албан хаагч хамрагдсан бөгөөд санал асуулгын мөрөөр гаалийн улсын ахлах байцаагч нартай тусгайлан уулзаж анхааруулга, чиглэлийг өгч ажилласан.</p> <p>3. <u>Дархан-Уул аймаг дахь гаалийн газарт:</u> Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 27 төрийн тусгай албан хаагчаас 26 албан хаагч нууц санал асуулгад оролцсон. Санал асуулгыг 5 агуулгын хүрээнд бэлтгэж, байгууллагын албаны ГХБХЦА viber групп байршуулан саналыг авсан. Судалгаанд оролцогчдоос өгсөн үнэлгээний үзүүлэлтээс харахад 5 асуултын дүнгээр байгууллагын төрийн албан хаагч нарын дунд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсэж байгаагүй гэж 100 хувь хариулсан байна. /2.3 дах арга хэмжээний нотломжуудыг хавсаргав./</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилд байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдаас нууц санал асуулга авч ажиллах арга хэмжээний хүрээнд харьяа гаалийн газар, хороодоос Замын-Үүд дэх гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газруудад зохион байгуулан ажиллаж санал асуулгын үр дүнд тулгуурлан холбогдох арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Санал асуулга авч ажиллаагүй байгаа харьяа гаалийн газар, хороодод сүүлийн хагас жилд дээрх ажил арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p style="text-align: center;">Үнэлгээ: 70 хувь</p> <p>Тайлбар: АТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлагналтын хэрэгжилт хангалтгүй байна. 2 үзүүлэлтийн үнэлгээний дунджаар үнэлсэн.</p>	
Гурав.Бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулах чиглэлээр					
3.1	Харьяа гаалийн газар, хороодын дарга нарын тушаал, шийдвэрээр албан хаагч нарт чөлөө олгож байгаа байдалд газар, хороо тус бүрээр дүн шинжилгээ хийх;	- Газар, хороо тус бүрд дүн шинжилгээ хийсэн байх; - Үр дүнг үндэслэн тодорхой арга хэмжээ авсан байх.	2-4 дүгээр улиралд	<p>Уг арга хэмжээг сүүлийн хагас жилдээ багтаан хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p style="text-align: center;">Үнэлгээ: 30 хувь</p> <p>Тайлбар: Харьяа гаалийн газар, хороод албан хаагч нарт чөлөө олголтын байдалд дүн шинжилгээнээс гарсан үр дүнд үндэслэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх. 2 үзүүлэлтийн үнэлгээний дунджаар үнэлсэн.</p>	30
3.2	Харьяа гаалийн газар, хороодод ажиллаж	- Газар, хороо тус бүрд дүн шинжилгээ	2-4 дүгээр улиралд	<p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тогтоосон “Албан тушаалын тодорхойлолт”-д нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх арга хэмжээний хүрээнд Гаалийн ерөнхий газрын</p>	100

	<p>байгаа ажилтан, албан хаагч нар нь Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тогтоосон “Албан тушаалын тодорхойлолт”-д нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх;</p>	<p>э хийсэн байх; - Үр дүнг үндэслэн тодорхой арга хэмжээ авч шалтгаан, нөхцөлийг арилгасан байх.</p>	<p>даргын 2024 оны” А/103 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажилласан. Уг ажлын хэсэг нь дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах, мэдээлэл цуглуулах асуулгын хуудас”-ыг үндэслэн “Гаалийн байгууллагын ажлын байрны шинжилгээний асуулга”-ыг байгууллагын үндсэн чиг үүрэгтэй уялдуулан боловсруулж, Google Drive From ашиглан албан хаагчдаас авсан. Ажлын байрны цахим санал асуулгад нийт 1489 төрийн тусгай албан хаагчид хамрагдах боломжтойгоос 922 буюу нийт албан хаагчдын 61.9 хувь нь хамрагдсан.</p> <p>2. Сангийн сайдын 2024 оны “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 6 дугаар тушаал, Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны “Бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай” А/123 дугаар тушаал, Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөөг үндэслэн шинээр боловсруулан батлуулах, чиг үүргийг нь өөрчлөх шаардлагатай албан тушаалын тодорхойлолтын нэрсийн жагсаалтыг бэлтгэн гаргасан. Шинээр боловсруулан батлуулах 31 албан тушаалын тодорхойлолт, Чиг үүрэг өөрчлөх шаардлагатай 72 албан тушаалын тодорхойлолт, Өөрчлөлт ороогүй 60 албан тушаалын тодорхойлолтын нэрсийн жагсаалтыг гаргасан.</p> <p>3. Ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн 163 албан тушаалын тодорхойлолтуудыг нэгтгэн, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолтын маягт”-ын дагуу бэлтгэн дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулийг үндэслэн гаалийн байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний хэлбэрт цахим гэсэн хэлбэр нэмэгдсэн. Үүний дагуу байгууллагын бүтэц, орон тоо өөрчлөгдөж, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөх болсон тул “Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо” өөрчлөгдсөн. ➤ Сангийн сайдын 2023 оны 135 дугаар тушаалыг үндэслэн нийт албан хаагчдын албан тушаалын зэрэглэл өөрчлөгдсөн. ➤ Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” 2 дугаар тогтоолыг үндэслэн мэргэшил, туршлагад өөрчлөлт орсон. ➤ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” А/146 дугаар тушаалыг үндэслэн мэргэжилд өөрчлөлт орсон. <p>4. Гаалийн ерөнхий газрын дарга, дэд даргын албан тушаалын тодорхойлолтын төслийг Хуулийн хэлтсээр хянуулж, Сангийн яаманд хүргүүлэхэд бэлэн болсон.</p> <p>5. Албан тушаалын тодорхойлолтын төслийн эцсийн хувилбарыг холбогдох нэгжүүдийн удирдах албан тушаалтнуудаар хянуулж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах явцад 15 албан тушаалын тодорхойлолтыг эцэслэн баталгаажуулах ажил хийгдээгүй байна.</p> <p>/3.2 дах арга хэмжээний нотломжуудыг хавсаргав./</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Сангийн сайдын 2024 оны “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 6 дугаар тушаал, Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны “Бүтэц,</p>	
--	---	---	---	--

				<p>орон тоог шинэчлэн батлах тухай” A/123 дугаар тушаал, Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөөг үндэслэн шинээр боловсруулан батлуулах, чиг үүргийг нь өөрчлөх шаардлагатай нийт 163 АТТ-ын төслийг батлуулахад бэлэн болгосон.</p> <p style="text-align: center;">Үнэлгээ: 100 хувь</p>	
3.3	<p>Гаалийн хяналтын бүсэд нэгэн зэрэг үйл ажиллагаа явуулдаг бусад төрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг ялгаж салгахад чиглэсэн гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан мэдээллийг бэлтгэн олон нийтэд түгээх арга хэмжээ авах.</p>	<p>Олон нийтийн цахим сүлжээ /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграмм, цахим хуудас/-д тухай бүр мэдээлэл байршуулсан байх.</p>	<p>2-4 дүгээр улиралд</p>	<p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар байгууллагын үйл ажиллагааг өөрийн байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан сурталчлан олон нийтийн цахим сүлжээ /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграмм, цахим хуудас/ - бэлтгэн олон нийтэд түгээх арга хэмжээ авч ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гаалийн байгууллагаас шуудан илгээмж, карго ачаанд хийж байгаа рентген аппаратыг шалгалтын бичлэгийг 2 жил, камерын хяналтын бичлэгийг 3 сар хадгалдаг талаарх мэдээлэл. https://fb.watch/sW88njo2Nf/?mibextid=w8EBqM 2. Эхний хагас жилийн байдлаар хар тамхи мансууруулах бодисыг шуудангаар илгээхийг завдсан 11 зөрчил илрүүлсэн талаарх мэдээлэл. /ETV телевиз/- https://fb.watch/sW8z79uVUo/?mibextid=w8EBqM 3. Гаалийн хяналтад үүрэг гүйцэтгэж эрэлч нохой 2023 оны төрийн 8 байгууллагын дунд зохиогдсон албаны эрэлч нохойн ур чадварын тэмцээнд цом, алтан медаль авсан талаарх мэдээлэл https://fb.watch/sW84xxSFXA/?mibextid=w8EBqM 4. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт “Нээлттэй хаалганы өдөр” DHL гаалийн хяналтын бүсэд зохион байгуулсан талаарх мэдээлэл https://fb.watch/sW84xxSFXA/?mibextid=w8EBqM <p>Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар байгууллагын үйл ажиллагааг бусад байгууллагатай хамтран олон нийтийн цахим сүлжээ /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграмм, цахим хуудас/ - бэлтгэн олон нийтэд түгээх арга хэмжээ авч ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 24 tsag.mn: Гаалийн хяналтын бүсэд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдах талаарх мэдээлэл https://www.24tsag.mn/a/227009?fbclid=IwZXh0bgNhZW0CMTEAAR3-90DpXa9n8ZDS- 2. Arslan.mn: Гаалийн байгууллагаас Гаалийн ерөнхий газрын харьяа Улс хоорондын шуудан илгээмж, карго ачаа бараанд хэрхэн хяналт хийдэг талаар /Live/ https://www.facebook.com/ 3. Asu.mn: Гаалийн байгууллагаас Улс хоорондын шуудан илгээмж, карго ачаа бараанд хэрхэн хяналт хийдэг талаар /Live/ мэдээлэл https://www.facebook.com/eaglenewssocial/videos/722830939922173 4. Newswire.mn: Гаалийн байгууллагаас Улс хоорондын шуудан илгээмж, карго ачаа бараанд хэрхэн хяналт хийдэг, хэрхэн ажилладаг талаар /Live/ мэдээлэл https://newswire.mn/n/34713 5. Mnb.mn: Гаалийн байгууллагаас Улс хоорондын шуудан илгээмж, карго ачаа бараанд хэрхэн хяналт хийдэг талаар /Live/ https://www.mnb.mn/i/310325 6. Zindaa.mn Гаалийн байгууллагаас Улс хоорондын шуудан илгээмж, карго ачаа бараанд хэрхэн хяналт хийдэг талаар /Live/ мэдээлэл https://www.facebook.com/zindaaofficial/videos/444416744628233 7. Mand.mn: Өөрийн хувийн мэдээлэл болон шуудангийн хаягаа бусдад ашиглуулахгүй байхыг талаарх мэдээлэл https://mand.mn/%D0%B1- 	100

				<p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар байгууллагын үйл ажиллагааг нийт 12 удаагийн мэдээ, мэдээллийг сурталчлан олон нийтийн цахим сүлжээгээр /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграмм, цахим хуудас/ олон нийтэд түгээх арга хэмжээ авч ажилласан.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ: 100 хувь</p>	
<p>Дүгнэлт: Арга хэмжээ тус бүрийн үнэлгээг авч үзвэл Дундаж үнэлгээ 89.17 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.</p>					

Шударга байдлын үнэлгээг сайжруулах төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн биелэлтийн нийт 12 арга хэмжээний биелэлтийн дундаж үнэлгээ 89.17 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.